



GRATA
INTERNATIONAL

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ХОЛБОГДОХ ЖУРМУУД

ГРАТА Интернэшнл Монголиа

<https://gratanet.com/regions/mongolia>

ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭ: ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ХОЛБОГДОХ ЖУРМУУД БАТЛАГДЛАА

Монгол Улс 2019 оны аравдугаар сард Санхүүгийн хориг арга хэмжээ авах олон улсын байгууллага (ФАТФ)-ын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орнуудын тоонд орж, үүнээс 1 жилийн дараа 2020 оны аравдугаар сард тус жагсаалтаас амжилттай гарсан байдаг.

Энэхүү жагсаалтаас гарах явцад ФАТФ-ын зүгээс гаргасан техник, мэргэжлийн 40 зөвлөмжийн 15 дугаарт “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг хянаж зохицуулах, бүртгэлжүүлэх, энэ төрлийн харилцааг хууль эрх зүйн орчинтой болгох” асуудал хөндөгдсөн юм.¹ Энэ хүрээнд улс орнуудыг шинэ технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ, тодруулбал виртуал хөрөнгөтэй холбоотой мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрэх эрсдлийг үнэлж, хууль эрх зүйн орчин бий болгохыг үүрэг болгосон байдаг. Үүний хүрээнд Монгол Улсын Их Хурал 2021 оны 12 сарын 17-ны өдөр “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль” –ийг баталж, 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Тус хууль мөрдөгдөж эхэлснээр Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” эсвэл энд дурдсан байдлаар нэрлэх/ хууль болон түүнд нийцүүлэн гаргасан журмын шаардлагыг хангасан Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэж, тэдгээрийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх эрх зүйн орчин бүрдсэн юм.

Монгол Улсад криптовалютын арилжаа хийдэг хэд хэдэн цахим хуудас, нэг АТМ байгаа бөгөөд үүнтэй холбоотой үйлчилгээ нь Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдөх, төлбөр тооцооны үйлчилгээнд хамаарахгүй бөгөөд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг аль нэг байгууллагын хяналт, зохицуулалт дор байдаггүй. Тодруулбал хэрэглэгч цахим хуудсаар дамжуулан зөвхөн өөрийн сонголтын хүрээнд биткойн болон бусад криптовалютыг биржийн зарчмаар арилжаалж байна. Өөрөөр хэлбэл дуудлага худалдаа нь арилжааны зарчим, зах зээлийн зарчим буюу эрэлт нийлүүлэлт, арилжаанд оролцогчийн хариу үйлдэл дээр тулгуурлан явагдаж байгаа юм. Сүүлийн үед IEO, ICO хийх замаар дотоодын зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлэх нь нэмэгдэж байна. Тухайлбал 2021 оны сүүлийн улиралд 4 байсан токены тоо 41 болтлоо өсөж (Lemon Press, 2021), зах зээл дээр томоохон эрсдэлийг бий болгож буй.

Ийнхүү энэ төрлийн эрх зүйн орчныг нэн яаралтай бүрдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Санхүүгийн зохицуулах хороо 2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам” болон “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”, 2022 оны 05 сарын 25 –ны өдөр “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох, түр зогсоох, бүртгэлээс хасах журам” -ыг тус тус баталснаар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох, нарийвчилсан харилцааг тодорхой

¹ “The FATF Recommendations” 2022

болгох, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, ФАТФ-ын зөвлөмжийн болон хуулийн хэрэгжилтийг хангах нөхцөл бүрдсэн юм. Тодруулбал, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”-аар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэх, бүртгэхээс татгалзахтай холбоотой харилцааг, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-аар зохистой засаглал, үйл ажиллагаа, өөрийн хөрөнгийн хэмжээ, тайлан мэдээнд тавигдах шаардлагыг тодорхойлохтой холбогдох харилцааг тус тус зохицуулсан (Санхүүгийн зохицуулах хороо, 2022).

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 4 сарын дараа буюу **2022 оны 6 дугаар сарын 25-наас Санхүүгийн зохицуулах хороо виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэж эхэлсэн ба хууль хэрэгжихээс өмнө үйл ажиллагаа эхлүүлсэн биржүүдийн хувьд 2022 оны 9 сарын 25-ний өдөр гэхэд бүртгэгдсэн байх ёстой.** Хорооноос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэх ажиллагаа эхэлж буйтай холбоотойгоор дээрх журмуудаар зохицуулсан асуудлыг тоймлон хүргэж байна.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ:

- Хүн, хуулийн этгээд, гэрээ хэлцэлд оролцогчийн нэрийн өмнөөс, тэдгээрийн захиалгаар, эсхүл тэдгээрт зориулан хийж байгаа дараах үйл ажиллагааг Виртуал хөрөнгийн үйлчилгээ байхаар зохицуулсан:
 - a) Виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд нь арилжих;
 - b) Нэг болон олон төрлийн виртуал хөрөнгийг хооронд нь арилжих;
 - c) Виртуал хөрөнгийг шилжүүлэх (бусдын нэрийн өмнөөс виртуал хөрөнгийг нэг виртуал хөрөнгийн хаягаас эсхүл данснаас нөгөө рүү шилжүүлэх);
 - d) Виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах;
 - e) Виртуал хөрөнгийг олон нийтэд санал болгох, худалдахтай холбоотой санхүүгийн үйл ажиллагаанд оролцох болон үйлчилгээ үзүүлэхийг тус тус заасан.

Монголбанк а, b –д заасан виртуал хөрөнгийн үйл ажиллагаанд, Санхүүгийн зохицуулах хороо с, d, e –д заасан виртуал хөрөнгийн үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулах, хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Бүртгэлийн үйл ажиллагаа нь шимтгэлтэй байх бөгөөд урьдчилсан байдлаар 40,000 – 80,000 төгрөг байхаар тогтоожээ.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч:

- Дээр дурдсан үйлчилгээний аль нэгийг эсхүл хэд хэдийг үзүүлэхээр энэ хуульд заасны дагуу бүртгүүлсэн Монгол улсын ашгийн төлөө хуулийн этгээдийг хэлнэ.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага:

1. Тухайн хуулийн этгээдийн үзүүлэх үйлчилгээ нь дээр дурдсан виртуал хөрөнгийн үйлчилгээнд хамаарсан байх;
2. Олон улсад нийтлэг ашиглагддаг бөгөөд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хүлээн зөвшөөрсөн технологийг ашигладаг байх;

3. Хүсэлт гаргагч болон хүсэлтэд дурдсан үйл ажиллагаатай холбогдох бусад этгээдийн мэдээлэл тодорхой байх;
4. Тухайн үйл ажиллагааг явуулах бүтэц, зохион байгуулалт, мэргэшсэн хүний нөөцтэй байх;
5. Дотоодын хяналт болон мэдээллийг хадгалах системтэй байх;
6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах тогтолцоо, автомат хяналтын системтэй байх;
7. Өөрийн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны байх;
8. Хууль болон Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон бусад шаардлага.

I. “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам” –ын тойм

Энэхүү журмаар Санхүүгийн зохицуулах хорооноос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлэх хүсэлт гаргагчийг бүртгэх, бүртгэхээс татгалзахтай холбогдсон харилцааг зохицуулжээ. Журмын үйлчлэх хүрээнд хамаарах этгээд нь Монгол улсад бүртгэлтэй ашгийн төлөө хуулийн этгээд байх ба тухайн этгээдийн Монгол улсад болон Монгол улсаас гадаад улс руу виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцаанд үйлчилнэ.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэх хүсэлт гаргагчид тавигдах шаардлага:

1. Дээр дурдсан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлагуудыг хангасан байх;
2. Дээр дурдсан виртуал хөрөнгийн үйлчилгээг эрхлэх хүсэлт гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ тус бүр 400.0 сая төгрөгөөс доошгүй байх;
3. Хувь нийлүүлсэн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээс бусад мөнгөн хөрөнгөөс бүрдсэн байх;
4. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх;
5. Хүсэлт гаргагч тав буюу түүнээс дээш гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ба тэдгээрийн хоёроос доошгүй нь хараат бус гишүүн байна;
6. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч өөрийн программ хангамж дээр виртуал хөрөнгийг арилжих, арилжаанаас хасахтай холбогдох зохицуулалтыг тусгасан байна;

7. Энэ журамд заасан бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц болон бусад шаардлага;

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлэх хүсэлт гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл дараах дүрэм, журам, бодлогын баримт бичгийг баталсан байна:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;
2. Хуулийн этгээдийн дөрвөн жилийн бизнес төлөвлөгөө;
3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөө, дотоод хяналтын хөтөлбөр;
4. Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам;
5. **MNS ISO/IEC 27001 стандартын шаардлага**, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлсэн мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны журам;
6. Дотоод мэдээллийг хууль бусаар ашиглахаас сэргийлэх журам;
7. Арилжааг урвуулан ашиглахаас сэргийлэх, хяналт тавих журам;
8. Үйл ажиллагааг түр зогсоох, хязгаарлалт тогтоох, татан буугдах, үйлчилгээ зогсох, кибер халдлага, түрэмгийлэлд өртөх зэрэг онцгой нөхцөл байдал үүссэн үед авах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө;
9. Виртуал хөрөнгийн үйлчилгээг эрхлэхтэй холбоотой үйл ажиллагааны журам;
10. Бусад шаардлагатай журам.

Виртуал хөрөнгийг олон нийтэд санал болгох, худалдахтай холбоотой санхүүгийн үйл ажиллагаанд оролцох болон үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой журамд дараах зүйлсийг тусгасан байна:

1. Нийтэд санал болгох виртуал хөрөнгө гаргагч болон тухайн виртуал хөрөнгө, түүний танилцуулгад тавигдах шаардлага;
2. Нийтэд санал болгох виртуал хөрөнгө гаргагчийн биелүүлэх үүрэг, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлэх мэдээллийн агуулга, хугацаа;
3. Нийтэд санал болгон гаргасан виртуал хөрөнгийг бүртгэлээс хасах нөхцөл;
4. Бусад.

Виртуал хөрөнгийн үйлчилгээг эрхлэх хүсэлт гаргагч дараах бүтэц, зохион байгуулалт, тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нөөцтэй байна:

1. Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;

2. Мэдээллийн технологи, аюулгүй байдал хариуцсан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;
3. Харилцагчийн үйлчилгээний нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;
4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих болон комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хариуцсан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх ба хэрэгжилтэд хяналт тавих этгээд нь төлөөлөн удирдах зөвлөл байх;
5. Виртуал хөрөнгийн үйлчилгээг эрхлэхтэй холбоотой үйл ажиллагааг хариуцсан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байна.

Хүсэлт гаргагч виртуал хөрөнгийн үйлчилгээг үзүүлэхэд шуурхай, тасралтгүй, үйл ажиллагааны онцлогт тохирсон тусгай программ хангамжтай байх бөгөөд уг программ хангамж нь дараах шаардлагыг хангасан байна:

1. Арилжаанд оролцогчид нэгнийгээ таньж мэдэх боломжгүй байх;
2. Харилцагчийн хувийн мэдээлэл гуравдагч этгээдээс нууц байх;
3. Зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, шинэчлэх боломжтой байх;
4. Олон нийтэд мэдээлэл хүргэх хэсэг буюу нээлттэй самбартай байх;
5. Арилжааны хяналтын системтэй байх;
6. Албан ёсны лицензтэй аюулгүй байдлыг хангах системтэй байх

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙГ БҮРТГЭХ

1. Хүсэлт гаргагч Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэхэд ирүүлэх баримт бичгийг нотлох баримтын хамт Хороонд хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.
2. Хороо нь хүсэлт гаргагчийн бүртгүүлэх хүсэлт, шаардлага хангасан бүрэн гүйцэд баримт бичгийг хүлээн авснаас хойш зургаан /6/ сарын дотор бүртгэх асуудлыг шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд энэ хугацааг зургаа /6/ хүртэл сарын хугацаагаар сунгаж болно.
3. Бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу, нотлох баримт нь шаардлага хангаагүй бол хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэж, нэмэлт баримт бичгийг шаардаж болно.
4. Хүсэлт гаргагчийн бүртгүүлэх хугацааг зохих шаардлага хангасан, бүрдэл бүрэн баримт бичгийг ирүүлсэн өдрөөс эхлэн тооцно.

5. Хорооноос хүсэлт гаргагчийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэсэн тохиолдолд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн нэгдсэн бүртгэлд бүртгэн, зохих зааврын дагуу хувийн хэрэг нээн хөтөлнө.
6. Хүсэлт гаргагч нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлсэн тохиолдолд компанийн дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээнд холбогдох тэмдэглэгээг хийлгэж, хуулбарыг хүсэлт гаргагчийн бүртгүүлэх шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙГ БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗАХ

1. Бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;
2. Эрх бүхий албан тушаалтан болон холбогдох этгээд нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдэд тавигдах шалгуурыг хангаагүй;
3. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль тогтоомж болон бүртгэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй.

Хүсэлт гаргагч баримт бичгийн бүрдэл дутуу гэх мэдэгдлийг хүлээн авснаас хойш Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд заасан баримт бичгийн бүрдлийг хангаж бүртгүүлэх хүсэлтээ ажлын 30 өдрийн дотор дахин гаргаагүй тохиолдолд хүсэлтийг буцааж, хүсэлт гаргаагүйд тооцно.

Хороо виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

II. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журмын тойм

Энэхүү журмаар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч /цаашид "ВХҮҮ" гэх/-ийн зохистой засаглал, үйл ажиллагаа, өөрийн хөрөнгийн хэмжээ, тайлан мэдээнд тавигдах шаардлагыг тодорхойлохтой холбогдох харилцааг зохицуулжээ. ВХҮҮ нь харилцагчийн эрх ашгийг хамгаалж, виртуал хөрөнгийн зах зээлийн шударга өрсөлдөөнийг дэмжиж ажиллана.

ВХҮҮ нь дотоод мэдээллийг хууль бусаар болон арилжааг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах захиалга, арилжаанд дотоод хяналт, шалгалтыг тогтмол хэрэгжүүлнэ:

1. өндөр үнийн дүнтэй;
2. үнэ ханшийн өсөлт, бууралт ихтэй;
3. үнэ ханшид нөлөөлөхүйц үнээр, цөөн тоо ширхгээр арилжсан;
4. холбогдох болон нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн хооронд 5 ба түүнээс дээш удаа арилжаа хийгдсэн;
5. хэвийн бус, анхаарал татсан гэж үзсэн бусад.

<https://gratanet.com/regions/mongolia>

Виртуал хөрөнгийн арилжааны хэлцэл биелсний дараа харилцагчийг дор дурдсан мэдээллийг авах боломжоор хангана:

1. Виртуал хөрөнгийн нэр;
2. Хэлцэл биелсэн хугацаа;
3. Арилжсан виртуал хөрөнгийн хэмжээ, үнэ ханш;
4. Бусад шаардлагатай мэдээлэл.

ВХҮҮ нь арилжааг дараах аргаар зохион байгуулах боломжтой байна:

1. Зах зээлийн үнийн арга (market order);
2. Нөхцөлт захиалгын арга (limit order).

ВХҮҮ нь арилжаанаас хассан виртуал хөрөнгийн мэдээллийг тайлбарын хамт 24 цагийн дотор Хороонд албан бичгээр хүргүүлнэ.

Дараах заалтыг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Виртуал хөрөнгийг шилжүүлэх үйл ажиллагааг эрхлэхэд шилжүүлэгч ВХҮҮ нь гурван сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүнтэй виртуал хөрөнгийг шилжүүлэхэд дараах мэдээллийг хүлээн авагч ВХҮҮ-д хүргүүлнэ:

1. шилжүүлэгчийн овог, нэр/хуулийн этгээдийн нэр;
2. шилжүүлэгчийн регистрийн дугаар;
3. шилжүүлгийн дугаар, эсхүл шилжүүлэгчийн хэтэвчний хаяг;
4. шилжүүлэгчийн бүртгэлтэй хаяг;
5. шилжүүлгийн зорилго;
6. Хүлээн авагчийн овог, нэр /хуулийн этгээдийн нэр;
7. Хүлээн авагчийн бүртгэлтэй хаяг;
8. Хүлээн авагч талын улсын нэр;
9. Хүлээн авагч талын ВХҮҮ-ийн нэр;
10. Шаардлагатай бусад.

Виртуал хөрөнгийг шилжүүлэх үйл ажиллагаанд тавигдах шаардлага:

1. ВХҮҮ нь бүртгэлгүй хэтэвчнээс шилжүүлэг хүлээн авах тохиолдолд дээр дурдсан мэдээллийг авсан байна.
2. Шилжүүлэгч ВХҮҮ дээрх мэдээллийг нэн даруй буюу шилжүүлэг хийхээс өмнө, эсхүл шилжүүлэг хийгдэх хугацаанд, аюулгүй хэлбэрээр хүргүүлсэн байна.
3. Шилжүүлэгч болон хүлээн авагч ВХҮҮ нь дээр дурдсан мэдээллийг дамжуулах, хүлээн авахаас өмнө хамтрагч ВХҮҮ-ийг тодорхойлж, харилцагчийг таньж мэдэх

үйл ажиллагааг хэрэгжүүлж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан эсэхийг үнэлсний үндсэн дээр шилжүүлгийг хийнэ.

4. Шилжүүлэгч ВХҮҮ нь дундын ВХҮҮ-ээр дамжуулан шилжүүлгийг хийсэн тохиолдолд мөн дээрх мэдээллийг хүргүүлнэ.
5. Шилжүүлэгч ВХҮҮ нь шилжүүлэг хийж байгаа харилцагчийн мэдээлэл, хүлээн авагч ВХҮҮ нь хүлээн авч буй харилцагчийн мэдээллийн үнэн бодит байдлыг шалгасан байна.
6. ВХҮҮ нь харилцагчийг таньж мэдэх эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлж, өндөр эрсдэлтэй гэж үзсэн этгээдрүү шилжүүлэг хийхгүй болон түүнтэй бизнесийн харилцаа тогтоохгүй.
7. Шилжүүлэгч болон хүлээн авагч ВХҮҮ нь дээр дурдсан мэдээллийг эрх бүхий байгууллагад түргэн шуурхай гаргаж өгөхөд бэлэн хадгална.
8. ВХҮҮ нь харилцагчийн виртуал хөрөнгийг шилжүүлэхдээ багадаа хоёр шатлалт танилт хийж, IP хаяг, хэтэвчний хаягийн үнэн зөв, бодит байдлыг баталгаажуулна.

Виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах үйл ажиллагааг эрхлэхэд дараах шаардлагыг хангаж ажиллана.

1. ВХҮҮ нь өөрийн хөрөнгийг 100 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй харилцагчийн виртуал хөрөнгийг хадгалж, удирдана.
2. ВХҮҮ нь өөрийн хөрөнгийн хэмжээний шалгуурыг улирал бүр тооцож, дээрх шаардлагыг хангаж ажиллана.
3. ВХҮҮ нь виртуал хөрөнгийг харилцагчийн даалгавраар хадгалах, удирдахдаа багадаа хоёр шатлалт танилт хийж, IP хаяг, хэтэвчний хаягийн үнэн зөв, бодит байдлыг баталгаажуулна.

Виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүгийн үйл ажиллагаанд оролцох болон үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага

1. ВХҮҮ нь виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой ажлыг зохион байгуулахаас өмнө тухайн виртуал хөрөнгө гаргагчтай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан байна.
2. ВХҮҮ нь виртуал хөрөнгийн танилцуулга, холбогдох баримт, мэдээллийг нийтэд санал болгох, худалдах ажиллагааг зохион байгуулахаас өмнө ажлын 10 өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.
3. ВХҮҮ нь виртуал хөрөнгийн танилцуулга, токеномикс, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

ВХҮҮ нь виртуал хөрөнгө гаргагчийн виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой ажлыг зохион байгуулахаас өмнө дараах мэдээлэлд үндэслэж шийдвэр гаргасан байна:

1. виртуал хөрөнгө, түүний төсөл нь эдийн засгийн үр ашигтай, бодитой, хэрэгжихүйц эсэх;
2. виртуал хөрөнгө гаргагч, түүний эцсийн өмчлөгч, эрх бүхий албан тушаалтан нь эдийн засгийн гэмт хэрэгт холбогдож байгаагүй, хугацаа хэтэрсэн өр зээлгүй, бизнесийн нэр хүндтэй, мэргэжлийн багтай эсэх;
3. виртуал хөрөнгийн суурилсан блокчэйн нь бүрэн хөгжүүлэлт хийгдэж, кибер аюулгүй байдлыг хангасан эсэх;
4. Бусад.

ВХҮҮ нь виртуал хөрөнгө гаргагчийн виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдах танилцуулгад дор дурдсан мэдээллийг тусгуулсан байна:

1. танилцуулга нь монгол хэл дээр бичигдсэн байх;
2. виртуал хөрөнгийн хэрэглээ, гаргаж буй зорилго, блокчэйний төрөл;
3. Виртуал хөрөнгө гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагааны талаар;
4. Виртуал хөрөнгө гаргагчийн хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл, эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь хэмжээ;
5. Виртуал хөрөнгө гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны нэр, зураг, ажлын туршлага, бусад нэмэлт мэдээлэл;
6. Виртуал хөрөнгө гаргагчийн сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан, түүний талаар аудитын байгууллагаас гаргасан дүгнэлт;
7. нийтэд санал болгох виртуал хөрөнгийн тоо хэмжээ, санал болгох үнэ;
8. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны төлөвлөгөө;
9. Виртуал хөрөнгийн хуваарилалт, тархалтын мэдээлэл;
10. Виртуал хөрөнгө гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн талаарх мэдээлэл;
11. Виртуал хөрөнгөнд хийсэн технологийн аудитын дүгнэлт;
12. Шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

ВХҮҮ нь дараах мэдээллийг өөрийн программ хангамж болон цахим хуудсанд ил тод, нээлттэйгээр байршуулна:

1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэсэн бүртгэл болон Виртуал арилжааны программ хангамжийг ашиглахтай холбоотой заавар, зөвлөмж, гарын авлага;
2. олон нийттэй харилцах утас, цахим шуудан, олон нийтийн сүлжээний хаяг, үйл ажиллагаа явуулж буй хаяг байршил;
3. өөрийн программ хангамжаар дамжуулан арилжиж буй дотоодын нийтэд санал болгон, худалдсан виртуал хөрөнгийн танилцуулга;

4. бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн талаарх мэдээлэл;
5. виртуал хөрөнгийн блокчэйн дээрх бүртгэлийн дугаар, ялгах тэмдэг, нийт гаргасан болон арилжиж буй тоо ширхэг, үнэлгээ, ханш, арилжааны дүн;
6. виртуал хөрөнгийн бүртгэлийн шаардлага, шалгуур, дүрэм, журам;
7. харилцагчийн санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээлэл;
8. ВХҮҮ-ийн үндсэн үйл ажиллагааны танилцуулга, санхүүгийн тайлан, бизнест шууд нөлөө үзүүлэхүйц хэлцлийн талаар;
9. үйл ажиллагаанд ашиглах программ хангамж, систем болон мэдээлэл, технологийн өөрчлөлт, шинэчлэлтийн талаар.

ВХҮҮ нь дараах мэдээллийг тогтмол, эсхүл тухай бүр программ хангамж болон цахим хуудсанд ил тод, нээлттэйгээр урьдчилан байршуулж, олон нийтэд мэдээлнэ:

1. арилжааны программ хангамж дахь виртуал хөрөнгийн үнэ ханш нь олон улсын зах зээл дээрх дундаж үнээс харьцангуй доогуур, эсхүл дээгүүр байх тохиолдолд үнийн зөрүүг тогтворжуулан хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хийж буй тухайн ВХҮҮ-ийн арилжааны талаар;
2. виртуал хөрөнгө гаргагч нь тухайн виртуал хөрөнгийн үнэ ханшийг огцом унахаас сэргийлэх зорилгоор ВХҮҮ-тэй тохиролцож, холбогдох гэрээ байгуулсны үндсэн дээр өөрөө эргүүлэн худалдан авах ажиллагааны талаар.

Мэдээлэл, тайлагнал

1. ВХҮҮ нь хууль тогтоомж, энэ журамд заасан мэдээллийг бүрэн гүйцэд, үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүйгээр тогтоосон хугацаа болон тухай бүрд харилцагч, олон нийтэд мэдээлж, Хороонд хүргүүлж тайлагнана.
2. ВХҮҮ нь жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор, хагас жил, улирлын санхүүгийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Хороонд тогтмол хүргүүлнэ.
3. ВХҮҮ нь аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан жилийн санхүүгийн тайлан, дүгнэлтийг дараа оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

ВХҮҮ нь дараах мэдээллийг агуулсан үйл ажиллагааны жилийн тайланг дараа оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд тогтмол хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ:

1. тайлант жилд ВХҮҮ-ийн орлогод нөлөөлсөн хүчин зүйлс;
2. санхүүгийн нөөцөөр бизнесийн үйл ажиллагаанаас бий болсон өр төлбөрийг бүрэн хариуцах болон шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод эх үүсвэрээс санхүүжилт татах боломжтой эсэх;
3. бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл, төрөлжилт, өөрчлөлт;

4. хадгалж, удирдаж байгаа харилцагчийн виртуал болон мөнгөн хөрөнгийн тоон үзүүлэлт;
5. ашиглаж буй программ хангамж, систем, мэдээлэл, технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдалд хийлгэсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
6. сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл, тухайн хэлцэлд оролцогч талууд;
7. эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, дотоод аудитын ажлын тайлан;
8. бусад мэдээлэл.

ВХҮҮ нь харилцагчийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

1. харилцагчийн өргөдөл, гомдлын бүртгэл хөтөлж, хүлээн авснаас хойш ажлын 7 өдрийн дотор хариу хүргүүлэх;
2. харилцагч, олон нийтийн виртуал хөрөнгийн эрсдэлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн ажлыг улирал бүр зохион байгуулах;
3. өөрийн ажилтнаас харилцагчийн хувийн мэдээллийг гадагш задруулахгүй, ажлын шаардлагаас бусад зорилгоор ашиглахгүй байх талаар баталгааг авах.

III. “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам” –ын тойм

Энэхүү Журмаар Санхүүгийн зохицуулах хороо нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам, зааврыг биелүүлж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авахтай холбогдох харилцааг зохицуулсан байна.

Хорооноос хийх хяналт шалгалт нь дараах төрөлтэй байна:

1. зайны хяналт шалгалт;
2. газар дээрх хяналт шалгалт.

(1) Зайны хяналт шалгалт: Зайны хяналт шалгалтаар ВХҮҮ нь хууль тогтоомж, холбогдох нөхцөл шаардлага, журмыг биелүүлж байгаа эсэхийг хянах, үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах замаар учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой байна.

(2) Газар дээрх хяналт шалгалт: Газар дээрх хяналт шалгалтын дүнд илэрсэн зөрчил, дутагдалд шалгалтын тайлангаар болон Улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгөх, шаардлагатай тохиолдолд зөрчлийн хэрэг нээх, эсхүл гэмт хэргийн шинжтэй тохиолдолд харьяаллын дагуу холбогдох байгууллагад шилжүүлнэ.

Газар дээрх хяналт шалгалтыг дараах үндэслэлээр хийнэ:

1. энэ журамд заасан зайны хяналт шалгалтын дүгнэлт;
2. төрийн эрх бүхий байгууллага, иргэдээс ирүүлсэн зохих нотлох баримттай санал, дүгнэлт, гомдол;
3. өмнө хийгдсэн хяналт шалгалтаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн хэрэгжилтийг тооцох;
4. ВХҮҮ-ийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, зөвлөмж;
5. ВХҮҮ тус журмын зайны хяналт шалгалтын хэсэгт заасан үүргийг хэрэгжүүлээгүй.

IV. “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох, түр зогсоох, бүртгэлээс хасах журам” -ын тойм

Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй "ВХҮҮ"-ийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох, түр зогсоох, бүртгэлээс хасахтай холбогдох харилцааг зохицуулна.

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХ

1. ВХҮҮ-ийн гүйлгээ илгээх, хүлээн авах, харилцагч, харилцагчийн хүрээ хязгаар, гүйлгээ хийгдэх гадаад улс, эсхүл тодорхой хуулийн этгээд, гадаад улсаас хөрөнгө оруулалт татах үйл ажиллагаанд болон тухайлсан виртуал хөрөнгө, түүнтэй холбоотой бүтээгдэхүүнд Хорооноос мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор хязгаарлалт тогтоож болно.
2. Хязгаарлалт тогтоох нь ВХҮҮ-ийн зайны болон газар дээрх хяналт шалгалт, бусад эрх бүхий байгууллагын дүгнэлт, зөвлөмж, мэдэгдэл, анхааруулга, тодорхойлолт зэрэгт үндэслэнэ.
3. ВХҮҮ нь хязгаарлалтаас чөлөөлүүлэх хүсэлтээ нотлох баримтын хамт Хороонд ирүүлж болох бөгөөд ирүүлсэн хүсэлтийг ажлын 20 өдрийн дотор хянаж, шийдвэрлэнэ.

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТҮР ЗОГСООХ

1. Түр зогсоосон нөхцөл байдал арилсан бол ВХҮҮ нь үйл ажиллагааг сэргээх хүсэлтээ нотлох баримтын хамт Хороонд ирүүлнэ.
2. Хороо нь хүсэлтийг ажлын 20 өдрийн дотор хянаж, шийдвэрлэнэ.
3. Хороо нь ВХҮҮ-ийн үйл ажиллагааг түр зогсоосон болон сэргээсэн шийдвэрээ олон нийтэд нээлттэй байршуулна.
4. Үйл ажиллагааг түр зогсоосон нь харилцагчийн зөвшөөрлөөр түүний виртуал болон мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ хийх ВХҮҮ-ийн эрхийг хязгаарлахгүй.

Хорооноос дараах тохиолдолд ВХҮҮ-ийн үйл ажиллагааг 3 сар хүртэл хугацаагаар түр зогсоож болно:

1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон салбарын зохицуулалтын журамд заасан нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах талаар Хорооноос хүргүүлсэн албан шаардлагыг заасан хугацаанд хангаж ажиллаагүй, үүргээ биелүүлээгүй;
2. Хороо, түүний хянан шалгагчаас ВХҮҮ-ийн үйл ажиллагаатай холбоотойгоор 2 болон түүнээс дээш удаа мэдэгдэл, анхааруулга хүргүүлсэн;
3. Гэмт хэрэг үйлдэх замаар үйл ажиллагаа эрхэлж байгаа талаар эрх бүхий этгээдээс үндэслэл бүхий хүсэлт гаргасан.

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙГ БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

1. ВХҮҮ-ийг бүртгэлээс хассан шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор тухайн компанийг дахин бүртгүүлэхтэй холбоотой хүсэлтийг хүлээн авахгүй.
2. ВХҮҮ-ийн бүртгэлээс хасагдсан компани нь төлөвлөгөө, харилцагчтай байгуулсан гэрээнд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч, тайланг Хороонд ажлын 20 өдрийн дотор ирүүлнэ.
3. ВХҮҮ-ийг бүртгэлээс хассан нь харилцагчийн зөвшөөрлөөр түүний виртуал болон мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ хийх ВХҮҮ-ийн эрхийг хязгаарлахгүй.

Хорооноос дараах тохиолдолд ВХҮҮ-ийг бүртгэлээс хасна:

1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон салбарын зохицуулалтын журамд заасан нөхцөл, шаардлагыг цаашид хангаж ажиллах боломжгүй болсон нь тогтоогдсон;
2. бүртгүүлснээс хойш 3 сарын дотор Виртуал хөрөнгийн үйл ажиллагааг эрхэлж эхлээгүй;
3. бүртгэлээс хасуулах тухай хүсэлтийг Хороонд ирүүлсэн, эсхүл татан буулгах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын болон шүүхийн шийдвэр гарсан;
4. баримт бичгийг хуурамчаар үйлдэн Хороонд бүртгүүлсэн нь тогтоогдсон;
5. түр зогсоосон хугацаанд үндэслэл болсон нөхцөл байдал, зөрчлийг арилгаагүй;
6. гэмт хэрэг үйлдэж харилцагчид их хэмжээний хохирол учруулсан нь тогтоогдсон.

Эх сурвалж:

1. “The FATF Recommendations” 2022.03. <https://bit.ly/39myJoG> - нэвтэрсэн 2022.05.14
2. Санхүүгийн зохицуулах хороо, “ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫГ БАТАЛЛАА”, <http://www.frc.mn/a/3959>
3. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль - <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390242606091>
4. “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 174 дүгээр тогтоолын хавсралт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468519071371&showType=1>
5. “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 175 дугаар тогтоолын хавсралт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468526158811>
6. “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 305 дугаар тогтоолын хавсралт, https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530417750751&fbclid=IwAR1ESjJfcUdHhkylGBFol6R_x0h1rRRfWcwcZKOWJ3SveQpve7uGzoP5Pps
7. “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох, түр зогсоох, бүртгэлээс хасах журам”, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 306 дугаар тогтоолын хавсралт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530417896241&fbclid=IwAR0DzX7jvQZo0EbBAUUqO9EjH6a-gOkqcFetJnP8KlbBbySkAhyZDZiCfmQ>
8. Lemon Press (2021) - https://lemonpress.mn/news/ieo_ihc/ - нэвтэрсэн 2022.05.14

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл, GRATA International Хуулийн Фирмийн партнер В.Болормаа болон эрх зүйч Т.Буянжаргалтай bvolodya@gratanet.com, btungalag@gratanet.com эсхүл +976 70155031 утсаар холбогдоорой.

Дэлхийн 20 улсад салбартай олон улсын хуулийн фирм GRATA Интернэшнлийн Монгол дахь оффис болох Өмгөөллийн “GRATA Интернэшнл Монголиа” ХХН энэхүү хууль зүйн мэдээллийг бэлтгэн хүргэж байна. Энэхүү хууль зүйн мэдээлэл нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд тодорхой асуудлаар нарийвчлан дүн шинжилгээ хийгээгүй болно. Уншигч та аливаа үйлдэл хийх (эс хийх) –ээс өмнө өөрийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах хэрэгтэй. Энэхүү хууль зүйн мэдээллийг ашигласны улмаас үүссэн аливаа үр дагавар, хохирлыг бид хариуцахгүй.